

“ЗӨГИЙН АЖ АХУЙД МӨРДӨХ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ДҮРЭМ”

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү дүрмээр зөгийн аж ахуйд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндсэн зарчмууд, шаардлага, стандартуудыг хангаж, тэдгээрийг хэрэгжүүлэх, хяналт тавих замаар зөгийн аж ахуй эрхэлж буй иргэний эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Дүрмийн зохицуулалт нь зөгийн аж ахуй эрхлэгч болон үйлдвэрлэлд оролцож буй иргэн, хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэр, ажилтны тоо, байршлаас үл хамааран дараахь хүрээг хамарна:

1.2.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 3.1-д заасан хөдөлмөрийн гэрээгээр ажилтан ажиллуулж байгаа ажил олгогч, түүнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан ажилтан;

1.2.2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, иргэд хоорондын гэрээгээр ажиллагч, хоршоо, нөхөрлөлийн гишүүн.

1.3.Зөгийн аж ахуйн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаа нь байнгын, тасралтгүй, тэдгээрт тавигдах хэм хэмжээний шаардлага нэгдмэл, мэдээлэл ил тод, үнэн бодит байна.

1.4.Дүрмийн хүрээнд “зөгийн аж ахуй” гэдгийг MNS6827:2020 стандартын дагуу “Зөгийг үржүүлэн, төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болон үйлчилгээ үзүүлдэг хөдөө аж ахуйн салбар” гэж ойлгоно.

Хоёр. Нэр томьёо

2.1.Дүрэмд тусгагдсан нэр томьёог дараахь байдлаар ойлгоно. Үүнд:

2.1.1.“хөдөлмөрийн гэрээ”-нэг талаас ажилтан нь ажил олгогчоос хуульд нийцүүлэн тогтоосон хөдөлмөрийн дотоод журмын дагуу тодорхой ажил гүйцэтгэх, нөгөө талаас ажил олгогч нь ажилтанд хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлс олгох, хууль тогтоомж болон хамтын гэрээ, хэлэлцээрт заасан хөдөлмөрийн нөхцөлөөр хангах тухай харилцан үүрэг хүлээсэн тохиролцоо;

2.1.2.”байнгын ажлын байр”-ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил, үүрэг;

2.1.3.“хөдөлмөрийн нөхцөл”- хөдөлмөрлөх явцад ажилтны ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчны хүчин зүйл;

2.1.4.“хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”- хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, аюулгүй нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт, техник, технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээ авах, эмчлэх, сувилах, нөхөн сэргээх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаа;

2.1.5.”эрсдэлийн үнэлгээ”-ажлын байрны эрсдэлд үнэлэлт өгөх үйл явц;

2.1.6.“үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл”- хүний эрүүл мэндэд нөлөөлж өвчлүүлэх, сэтгэхүйд өөрчлөлт оруулах, хөдөлмөрлөх чадварыг бууруулах, мэргэжлийн өвчин бий болгох уршиг бүхий үйлдвэрлэлийн хүчин зүйл;

2.1.7.“үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйл” - ажлын ээлжийн хугацаанд хурц хордлого, үйлдвэрлэлийн осолд хүргэх, хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулах хүчин зүйл;

2.1.8.”ажлын байран дахь эрсдэл”- иргэнийг үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчинд хүргэж болзошгүй ажлын байрны нөхцөл;

2.1.9.”ажлын байр”- иргэн, ажилтны гүйцэтгэх ажил үүрэгтэйгээ холбоотойгоор ажил олгогчийн шууд ба шууд бус хяналтын дор байх бүх байр;

2.1.10.“тусгай хувцас”- үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зориулалт бүхий хувцас, гутал, малгай, бээлий зэрэг хэрэгсэл;

2.1.11.“нэг бүрийн хамгаалах хэрэгсэл” - үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хэрэгсэл;

2.1.12.“ахуйн байр”- иргэн, ажилтны хөдөлмөрлөх хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн, тусгайлан төхөөрөмжилсөн хувцас солих, түр амрах, хооллох, бие засах, усанд орох, дулаацах зэрэг зориулалтын өрөө тасалгаа;

2.1.13.“хөдөлмөрийн аюулгүй нөхцөл” - ажилтанд нөлөөлөх үйлдвэрлэлийн хортой ба аюултай хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь хөдөлмөрийн аюулгүй байдлын тогтоосон хэм хэмжээнээс хэтрээгүй байх;

2.1.14.“хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт”- хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар эрх бүхий байгууллагаас тогтоосон хэм хэмжээ;

2.1.15.“мэргэжлээс шалтгаалсан өвчин”-хөдөлмөрлөх явцад үүссэн үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалсан өвчин;

2.1.16.“үйлдвэрлэлийн осол”- хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөх;

2.1.17.“хурц хордлого” -даатгуулагч хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа богино хугацаанд цацраг идэвхт буюу химийн бодисын нөлөөгөөр хордох.

2.1.18.“зөгийчин”- зөгийг арчилж маллан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлэх чадавхи бүхий мэргэжлийн хүн;

2.1.19.“галын аюулгүй байдал” - учирч болзошгүй гал түймрээс хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчин болон нийтийн ашиг сонирхлыг хамгаалсан байдал.

2.2.Уг дүрмийн 2.1-д тусгагдаагүй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой нэр томъёог Хөдөлмөрийн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн, Галын аюулгүй байдлын тухай болон холбогдох хууль тогтоомж, зөгийн аж ахуйн холбогдолтой нэр томъёог MNS 6827 : 2020, MNS 6829 : 2020, MNS 1551:1983, MNS 6294:2011 стандартуудад тусгагдсан утгаар хэрэглэнэ.

Гурав. Үйлдвэрлэлийн явц дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага

Үйлдвэрлэл нь /агаар, хөрс, ус/ зэрэг хүрээлэн буй орчныг бохирдуулахгүй, хортой бодисын агууламж заасан хэмжээнээс хэтрэхгүй нөхцөлд явагдана.

3.1. Зөгийг өвөлжүүлэхэд тавигдах шаардлага

3.1.1.Зөгийн өвөлжөө нь өвөлдөө 0-2 °C дулаан, (-2 °C-аас +4 °C-аас хэтрэхгүй), 75-85%-ийн харьцангуй чийгтэй, салхивчтай, дуу чимээ, гэрэл хулгана нэвтрэхээс хамгаалагдсан байх ба чимээ, шуугиан багатай, нөмөр дулаан, нарны тусгал сайтай газарт байгуулна.

3.1.2.Зөгийг өвөлжих хугацаанд нэг бүлд 25-аас доошгүй кг бал, 4-5 кг тоосормог байхаар тооцож, тэжээлээр хангана.

3.1.3.Намар зөгийг өдрийн температур 0 оC болсон үед буюу 11 дүгээр сарын 2-р хагасаас хойш өвөлжөөнд оруулна. Зөгийн хүчтэй бүлийг доод талд, сул бүл, бүлэнцрийг дээд талд байрлуулна. Зөгийг өвөлжөөнд байрлуулж, тайвширсны дараа нисгэвчийг онгойлгоно. Үүрний дээд салхивчийг тохируулан нээж болно.

3.1.4.Зөгийчин 7-10 хоног тутамд өвөлжилтийн байдал, өвөлжөөний агаарын чийг, дулааны хэм, тэжээлийн зарцуулалтыг шалгаж, тэмдэглэх ба зөгийн гэрийн нисгэвчийн хэсгийг сэтгүүрдэн цэвэрлэнэ. Өвөлжиж буй зөгийг дуу чимээ гаргалгүй, улаан гэрэл ашиглаж шалгана.

3.1.5.Зөгийг өвөлжилт, цаг агаараас хамааран 3 дугаар сарын дунд үеэс 4 дүгээр сарын эхэн үед гадна агаарын дулаан 10 °C-ээс дээш болсон үед өвөлжөөнөөс гаргана. Зөгийн тайван байдлыг хангах үүднээс гэрийн нисгэвчийг хааж, зөөн байрлуулсны дараа нисгэвчийг нээнэ. Урьдчилан цэвэрлэсэн талбайд зөгийн гэрийн нисгэвчийг зүүн-урд, урд зүгт харуулан хаврын бороо, цасны ус үүрэнд нэвтрүүлэхгүйн тулд урагш 5°C-ын налуу, суурь, тавиурь дээр байрлуулна.

3.1.6.Өвөлжөөнөөс гаргасан зөгийн бүлийг өдрийн температур 10 °C-аас багагүй дулаан өдөр нээн, үүр, хайрцаг, цаваг даавуу, дулаалгыг сольж, эх зөгийг шалган, бүлийн хүчээс хамааран жаазны тоог шахаж өгнө. Тэжээлтэй жааз тавьж өгнө. Өвөлжөөнд хэрэглэсэн зөгийн үүр, бусад хэрэгслийг сайтар цэвэрлэж, ариутган хатаана.

3.1.7.Өвөлжөөний дараа зөгийн үүрийг цэвэрлэн, үзлэг хийх явцад нозематоз, аспергиллэзын халдвар үүсэх эрсдэлтэйг анхаарна.

3.2. Зөгийг тэвэрлэх, нүүлгэх үеийн аюулгүй байдлыг хангах

3.2.1.Зөгийг ихэвчлэн нислэг дууссаны дараа буюу үдэш, шөнийн цагт тээвэрлэнэ. Харин сэрүүн, үүлэрхэг болон бага зэргийн бороотой үед зөгийнүүд үүрэнд бүрэн орсон нөхцөлд өдрийн цагаар тээвэрлэж болно.

3.2.2.Зөгийг тээвэрлэхийн өмнөх өдрүүдэд балыг хураасан, үүрний жинг хөнгөрүүлсэн байна.

3.2.3.Хэрэв үүр нь жаазаар дүүрээгүй бол жаазыг сайтар шахаж, тусгай бэхлэгчээр хөдөлгөөнгүй болгоно. Хэрэв тусгай бэхлэгч байхгүй тохиолдолд жаазнуудыг нэг тал руу нь шахаад хадаасаар бэхэлж болно. Салхивчинд тор хадах ба үүрийг ул таглаатай нь бэхэлнэ.

3.2.4.Зөгийн хүнд жинтэй бүлийг доод хэсэгт нь байршуулж, ачааны өндрийг газраас 3.3 м-ээс хэтрүүлэхгүй давхарлан ачиж, татлагаар сайтар бэхэлнэ.

3.2.5.Тээвэрлэх явцад хүн ам олонтой газар зогсохоос зайлсхийж, шаардлагатай тохиолдолд сүүдэр газар зогсолт хийж болно.

3.2.6.Тээвэрлэхдээ зөгийн гэрийн бүх бүрдэл хэсэг / ул, их бие, хүзүүвч, таг/-үүд нь хоорондоо бэхлэгдэн холбогдсон байхад анхаарна.

3.2.7.Зөгийг тээвэрлэхдээ гэрийн нүхийг сайтар битүүмжлэн, зөгийн үүрний нисгэвчийг хойш харуулж байрлуулна.

3.2.8.Зөгийг ачсан тэвшин дээр хүн суулгаж болохгүй.

3.2.9.Ачааг буулгахын өмнө бүлийг унагахаас болгоомжилж, зөгийн тайван байдлыг шалгана.

3.2.10.Зөгийг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн найдвартай ажиллагааг хангасан байна.

3.2.11.Зөгийн бүлийг ачих, буулгахад гадны хүнийг байлгахгүй.

3.2.12.Зөгийг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн хурд засмал замд 60 км/цагаас, орон нутгийн замд 20 км/цагаас ихгүй байна.

3.3. Зөгийг бэлчээрлүүлэх

3.3.1.Зөгийн суурь /балт ургамлын нөөцтэй бэлчээрт байрлуулсан хэсэг бүл/-ийг сүргийн тэжээлд хүрэлцэхүйц хэмжээний балт, тоост ургамал, усны эх үүсвэртэй органик газар тариалангийн талбай, байгалийн бэлчээрт байршуулна. Уг байршил нь органик бус тариалангийн талбай, эсхүл бохирдлын эрсдэл өндөртэй (хувиргасан амьд организм ашигласан таримлын талбай, суурин газар, үйлдвэрийн болон уул уурхайн бүс, асфальтан автозам, хогийн цэг гэх мэт) газраас 5 км болон түүнээс дээш зайд алслагдсан байна.

3.3.2.Зөгийн байгалийн бэлчээрийг тухайн нутгийн шавжны бүлэг, зүйлтэй хэрхэн нийцэх, аюулгүй байдал, балт ургамлын нөөц, зэрлэг ургамлын тоос хүртээх шаардлагыг харгалзан сонгоно.

3.3.3.Зөгийг талбайд байршуулахдаа нэгж талбай дахь балт ургамлын арвин, хураан авах боломжтой амтат шүүсний хэмжээ, ургамлын онцлогийг харгалзан бүлийн тоог тохируулна.

3.3.4.Зөгийг бэлчээрт байршуулахдаа өөрийн нэр, хаяг, утасны дугаарыг үлдээж, шаардлага гарсан үед бусад хүн холбогдож мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлнэ.

3.3.5.Зөгийн бүл, бүлэнцэрт тавигдах техникийн шаардлага нь Зөгийн бүл, бүлэнцэр MNS1551:1983 стандартад нийцсэн байна.

3.3.6.Зөгийг 25-30 бүлээр суурилж, суурь хооронд 10-15 км байхаар тооцно. Задгай усгүй газарт зөгийн суурийн дэргэд услууур байршуулна.

3.3.7.Зөгийг байршуулах бэлчээр нь инсектицид, пестицид зэрэг шавж устгах, хорт ургамалтай тэмцэх химийн бодисын сөрөг нөлөөгүй байх ба хулгана, шувуу, шоргоолж, баавгай зэрэг амьтдын аюулаас хамгаалагдсан байна.

3.3.8.Зөгийн суурийг чихэрлэг хүнсний үйлдвэрлэл, өөр зүйлийн зөгийн үүрний ойр байршуулж болохгүй.

3.3.9.Бэлчээрт нүүлгэхдээ зөгийн үүрийг сайтар таглаж, бэхлэн, салхивч, нисгэвчийг хааж, тээвэрлэх машинд анхааруулга хадаж, үдэш, шөнийн цагаар зөөвөрлөхдөө суурин газраар дайрахгүй байх талаар аюулгүй ажиллагааны зааварчилга өгнө.

3.3.10.Зөгийг зөөхдөө биеийн хажуу талаар аль болох алгуур хөдөлгөөнөөр өргөх ба замд тааралдах чулуу, саадыг зайлуулна. Зөгийн үүрийг нурууны хүчээр өргөхгүй, хөлөө нугаларалтын хүчээр өргөнө. Нурууны хүчээр өргөх буруу дадлаас үүдэн нурууны өвчтэй болох эрсдэлтэйг анхаарна.

3.4. Зөгийчинд тавих шаардлага, аюулгүй ажиллагаа

3.4.1.Зөгийтэй ажиллаж эхлэхийн өмнө зөгийн хоронд харшилтай эсэхийг тодорхойлуулсан, эсвэл мэдэх шаардлагатай.

3.4.2.Зөгийчин үйлдвэрлэлийн үндсэн үе шаттай уялдсан ажлын хуанли, бизнес төлөвлөгөө, учирч болох эрсдэлийн урьдчилсан тооцоог гаргасан байна.

3.4.3.Зөгийчин зөгий байрлуулсан газрыг сайтар судалж, зөгийн суурийг ус, галын эрсдэлд өртөхөөргүй, эвэр дулаан, салхи багатай, нөмөр газар, нисгэвчийг зүүн-урд, урд зүгт харсан байхаар байрлуулна.

3.4.4.Зөгийн бэлчээр, тэжээл, зөгийн өвчний түүх, эмчилгээ, үр дүн, зөгийн бал, бусад бүтээгдэхүүнийг хурааж авсан талаарх бүртгэлийг тогтмол хөтөлж, баталгаажуулна.

3.4.5.Зөгий маллах явцад зөгийн арчилгаа, маллагааны дэвтрийг заавал хөтөлнө.

3.4.6.Зөгийчин нь зөгийн үүрэнд үзлэг хийхдээ тайван, зөөлөн, цочихгүй байх, зөгийнд айдсаа мэдрүүлэхгүй байх арга барилыг эзэмшсэн байна.

3.4.7.Зөгийн бүлийн ард, хажуу талд нь зогсож онгойлгоно. Гэрийг онгойлгохын өмнө үүрний нисгэвчийг утуураар 2-3 удаа утна. Гэрийг нээгээд цаваг даавууг авахдаа 5-6 удаа утаж, зөгийг тайвшруулна.

3.4.8.Зөгийчин нь нарших, ам цангах, даралт ихсэхээс урьдчилан сэргийлэх, цаг агаарын нөхцөлд тохируулж хувцаслах, ажил, амралт, ачааллыг зохицуулах зэргээр аюулгүй ажиллагааны нөхцлийг хангана.

3.4.9.Өглөө эрт, үдээс өмнө зөгий нислэгт гарсан үеэр ажиллах зэргээр ажлын цагийг зөв тохируулна. Нислэг дууссаны дараа зөгийн үүрэнд үзлэг хийж болохгүй.

3.4.10.Зөгийтэй ажиллах, бэлтгэл ажлыг хангах явцад гадил жимс, сонгино, сармис идэх, архи, тамхи, согтууруулах ундаа, үнэртэн, энгэсэг хэрэглэхийг хориглоно.

3.4.11.Утуурыг ашиглах явцад цогтой утаа үлээлгэх, түлэх, өөрөө түлэгдэх, хорт утаа гаргах материал ашиглах, хордох, харшилтай болох зэрэг эрсдэлүүдээс хамгаална.

3.4.12.Бороотой, хэт халуун, манантай өдөр зөгийг үзэхийг хориглоно.

3.4.13.Байгаль, цаг агаарын хүчин зүйлс, араатан амьтны дайралт, галын аюул зэрэг эрсдэлийн үед хэрэглэх, тусламж дуудах зорилгоор гар утас, харшлын үед ашиглах анти-гистамины түрхлэг, бэлдмэлийг биедээ авч явна.

3.4.14.Зөгийтэй ажиллах үед гялгар өнгөтэй бөгж зэрэг гоёл чимэглэл зүүхийг хориглоно.

3.5. Бал хураах, ялгах үеийн аюулгүй ажиллагаа

3.5.1.Зөгийн бал хураах төлөвлөгөө гаргаж, балыг хаана, хэрхэн хураах, савлах болон шаардагдах багаж хэрэгслийг судлан, зохих бэлтгэлийг хангана.

3.5.2.Бал хураах үеэр зөгийг ургамал, амьтны гаралтай материал ашиглан май тавьж, утуураар сайтар утна. Энэ зорилгоор шатах, тослох материал ашиглахыг хориглоно. Зөгийн үүрэн дэх зөгийг устгаж, бал хураахыг хориглоно.

3.5.3.Бал ялгуурыг зөгийн сууриас зайдуу, тусгайлан тоногдсон байранд байрлуулж, балаар дүүрсэн жаазыг түүнд хийж эргүүлэн балыг нь ялгана. Балыг ялгахдаа гар хуруугаа гэмтэхээс болгоомжилно.

3.5.4.Зөгийн балыг битүү орчинд хураана.

3.5.5.Зөгийн балыг хураахдаа балтай жаазуудыг урдаар салган аваад тусгай зориулалтын газар, байранд ялгана.

3.5.6.Зөгийн балыг савлах, зөгийн аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах дулаан нь 45 °C-аас ихгүй байна.

3.6. Үзлэг, эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

3.6.1.Зөгийг халдварт болон халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг дараах байдлаар явуулна:

3.6.1.1. Зөгийн бүлийн арчилгааг сайжруулах

3.6.1.2. Зөгийн үүрийг тогтмол цэвэрлэж, ариутгах

3.6.1.3. Зөгийн бүлийн хашлага самбар, давхар, давхцуур, гэрийн ул, цаваг даавуу, дулаалга /дэр / зэрэг тоног хэрэгслийг ариутгах

3.6.1.4. Өвөлжөө, зөгийн суурь орчмын талбайг тогтмол ариутгаж цэвэрлэх

3.6.1.5. Өвчнийг зөв оношилж, тохирсон эмчилгээг цаг алдалгүй хийх

3.6.2.Зөгийг эмчлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг малын эмчийн зааврын дагуу гүйцэтгэнэ.

3.6.3.Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажлыг гүйцэтгэх ажилтан нь хувийн аюулгүй байдлыг хангах, эм, эмийн хэрэгсэл, бохир материалтай харьцах талаар зохих зааварчилга авсан, эрүүл мэндийн урьдчилсан болон үе шаттай үзлэгт хамрагдсан байна.

3.6.4.Зөгийн өвөлжөө, сархиагийг халдваргүйжүүлэх ажлыг орон сууцнаас 200 м, үйлдвэрлэлээс 100 м-ээс багагүй зайд хийнэ.

3.6.5. Агааржуулалтыг гадаах орчны агаарын хэм 10 хэмээс доошгүй, 25 хэмээс дээшгүй, салхины хурд 7м/с-ээс ихгүй байх үед комбинзон, маск бүхий өмсгөлтэй, тусгайлан бэлтгэгдсэн баг гүйцэтгэнэ.

3.6.6. Агааржуулалтын өмнө бүх цонх, агааржуулалтын нүхийг хааж, хангалттай агаар оруулсны дараа нээнэ.

3.6.7. Зөгийн гэрийг галын дөл, UV гэрлээр ариутгахдаа галын аюулгүй ажиллагааны дүрмийг баримтална.

3.6.8. Зөгийн үүрийг эм, эмнэлгийн бодисоор ариутгахдаа зааврын дагуу хэрэглэнэ.

3.6.9. Халдваргүйжүүлэх бодисыг хаалгатай шүүгээ, хэсэгчилсэн агааржуулалт бүхий газарт хадгалах ба зориулалтын саванд хаяна.

3.6.10. Халдваргүйжүүлэх, ариутгах, хортон шавьж устгах зэрэг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажлыг гүйцэтгэх ажилтныг ажлын тусгай хувцас, хагас түрийтэй резин гутал, хормогч, резин бээлий, респиратор, хамгаалалтын шил, ханцуйвчаар хангасан байна.

3.6.11. Зөгийн бүлд дараах үндсэн үзлэгийг цаг тухайд нь хийж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

3.6.11.1. Хаврын их үзлэг

3.6.11.2. Давхраа, давхцуураар өргөтгөхийн өмнөх үзлэг

3.6.11.3. Балны ид авцанд бэлтгэх, өргөтгөл хийх үеийн үзлэг

3.6.11.4. Балны ид авцын дараах үзлэг

3.6.11.5. Намрын их үзлэг

3.6.12. Үзлэгийн явцад гар шалбарах, шархлах, хавчуулах зэрэг механик гэмтэл авах, зөгийн авгалдай, үрвэлдэйг хайж нүд ядрах зэргээс урьдчилан сэргийлж, нуруу, бүсэлхий өвдөх тухай бүрт эмчид хандан, хамгаалалтын бээлийг тогтмол хэрэглэнэ.

3.6.13. Үзлэгийг агаарын дулаан сүүдэр газарт +10^o хэмээс доошгүй болсон үе буюу хавар, намрын улирал өдрийн дулаанд, зуны улирал өглөө эсвэл хэт халуун өнгөрсний дараа салхигүй өдрүүдэд зөгийг цочоож, уурлуулахгүй, нислэгт нь саад болохооргүйгээр хажуу талаас нь хийнэ.

3.6.14. Үзлэгийг хийхдээ тагийг авч ар талд нь тавих ба бүтээлгийг бага зэрэг сөхөж, утуураар зөөлөн утна. Дээд хэсгийн зөгийг доош орох үеэр үзлэгийг хийнэ.

3.6.15. Захын жаазыг үзэж, зөөврийн хайрцагтаа хийн, дараагийн жаазыг гэрийн хананд шахаж тавина. Өндөгтэй жаазыг голд, балтайг захад нь байрлуулна. Бал, зөгийтэй жаазыг босоогоор нь болгоомжтой үзнэ. Жаазнаас зөгийг суллахдаа гэрийн дотор жаазны хагасыг оруулж, чихэвчин дээрээс нь барьж, огцом сэгсэрнэ. Зөгийг үлдвэл үргээгүүрийн тусламжтай зайлуулна.

3.6.16. Олон давхраат гэрт зөгийн үзлэгийг хийхдээ давхар давхраар нь авч шалгана.

3.6.17. Зөгийг олон дахин цочроохоос сэрэмжилж, үзлэгийг тодорхой хугацаанд чанартай хийнэ.

3.6.18. Зөгийн тоног хэрэгслийг өвчнөөс урьдчилан сэргийлж, ариутгахад дараах бодисыг хэрэглэнэ:

3.6.18.1. Сүүний болон шоргоолжны хүчил

3.6.18.2. Оксалин болон цууны хүчил

3.6.18.3. Хүхэр

3.6.18.4. Байгалийн гаралтай гаа, евкалипт, камфор зэрэг эфирийн тос /

3.6.19. Усны уур, галын дөл, каустик содоор гэр, жаазыг шууд ариутгана.

3.6.20. Халдварт өвчний үүсгэгчээр бохирдсон жааз, сархиаг болон бусад материалыг устгана.

3.6.21. Зөгийн халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, халдваргүйжүүлэх арга хэмжээг заавар, “Мал эмнэлгийн лабораторийн шинжилгээнд зориулсан дээж авах, бэлтгэх, илгээх журам”-ын дагуу зохион байгуулна.

Дөрөв. Багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага

4.1. Зөгийн аж ахуйд зөгийн өвөлжөө, үүр хайрцаг багаж, хэрэгсэл хадгалах агуулахаас гадна гэр, утуур, ховхчуур, эх зөгийн дасгуур, үргээгүүр, идүүр, сүрэглэл барих сав, сэмж наах буланцар, жаазанд татах төмөр утас, эх зөгийг тэмдэглэгч, бүртгэлийн дэвтэр, шөвөг, бахь, алх, зөгийн гэрийн бэхэлгээ, лавны хутга, лав хайлуулах төхөөрөмж, лавны шүүлтүүр, бал хураагуур, балны шүүлтүүр зэрэг байгууламж, тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийг хэрэглэнэ.

4.2. Зөгийн өвөлжөө нь уг дүрмийн 3.1.1-д заасан шаардлагыг хангасан байна.

4.3. Зөгийн гэрийг MNS6829:2020 стандартын техникийн шаардлагад нийцүүлж хийнэ. Зөгийн үүр хайрцгийг нойтон цэвэрлэгээ хийх, сойздож угаах, уур, галын дөлөөр ариутгах, наранд

хатаах, UV гэрлээр шарах, бактери, вирус, мөөгөнцрийн эсрэг үйлдэлтэй ариутгагч бодисын сулхан концентрацитай уусмалаар ариутгах арга хэмжээ авна.

4.4.Багаж, хэрэгслийг дараах үед заавал цэвэрлэж, ариутган, шаардлагатай тохиолдолд шинэчилнэ. Үүнд:

4.4.1. Зөгийн үүр хайрцагийг солихын өмнө

4.4.2. Зөгийн үүрийг хадгалах

4.4.3. Зөгийн бүлүүдэд өвчин, халдвар гарсан үед

4.4.4. Багаж, хэрэгслийг дахин ашиглахын өмнө

4.4.5. Багаж, хэрэгслийг сууриудын хооронд зөөвөрлөх

4.4.6. Багаж, төхөөрөмж хэт хуучирсан

4.4.7. Халдвартай зөгийтэй ажилласан

4.5.Зөгийг тайвшруулах үүднээс тусгай зориулалтын утуурыг хэрэглэнэ. Утуурыг гал авалцах материалаас 3 м-ийн зайд саван дотор хадгална.

Тав. Галын аюулгүй байдалд тавигдах шаардлага

5.1.Зөгийн аж ахуй нь учирч болзошгүй гал түймрийн аюулаас ажиллагсад, зөгий болон бэлчээрийг хамгаалах ажлыг Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм” –ийн дагуу зохион байгуулна.

5.2.Галын аюулаас урьдчилан сэргийлэх, аюулын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар үйлдвэрлэлийн онцлогт тохирсон мэдээллийн булан, багаж хэрэгсэлтэй байна.

5.3.Галын ослын үед тухайн газрын хаяг байршил тэнд байгаа хүмүүс галын нөхцөл байдлын талаарх мэдээллийг аж ахуйн удирдлага болон гал унтраах албанд мэдэгдэнэ.

5.4.Галд өртсөн зөгийг шууд устгана.

5.5.Зөгийнд хатгуулсан тохиолдолд хатгуурыг чимхэн авч болохгүй. Хорыг давс, элсэн чихрийн хүчтэй уусмал, салфеткаар цэвэрлэнэ.

5.6.Ажилтанд галаас үүдэлтэй тууралт, загатнах, хавдах, бие сулрах, амьсгал давчдах, зүрх дэлсэх зэрэг харшлын шинж илэрвэл эрүүл мэндийн байгууллагад яаралтай хандана.

5.7.Гал унтраах үүргэвч, галын хор, 9 л-ээс багагүй устай сав, төмөр хүрз, галын тармуурыг утууртай ойролцоо байрлуулна. Утуурыг хэрэглэсний дараа гал бүрэн унтарсныг заавал шалгана.

5.8.Утуурыг асаахдаа бензин, креосин, дизелийн түлш хэрэглэхийг эрс хориглоно.

5.9.Утууртай ажиллаж байх үедээ утуурын доод нүхээр галын оч хаяж байгаа эсэхийг шалгана. Хэрэв оч хаяж байвал утаа үүсгэж буй материалыг бага зэрэг чийгшүүлнэ.

Зургаа. Ажилтны хамгаалах хэрэгсэлд тавигдах шаардлага

6.1.Зөгийчний хамгаалах хэрэгсэл нь зориулалтын малгай, ажлын хувцас, бээлий, ханцуйвч, гутлаас бүрдэнэ.

6.2.Ажлын хувцасны техникийн шаардлага нь MNS ISO13688:2000 стандартад нийцсэн, хөл болон гарны бугуй хэсгээр бариу, цагаан, цайвар шар, ногоон өнгөтэй байна. Улаан, хар өнгийн болон үслэг, ноосон хувцас өмсөхийг хориглоно. Доош тонгойход өмдний шуумаг нь шагайг давж байхаар хэмжээг тохируулна. Ажлын хувцсандаа цоорхой үүссэн эсэх, хөлс, дизель түлш мэтийн хурц үнэр байгаа эсэхийг тогтмол шалгана. Зөгий хөлсний үнэрт мэдрэг тул халуунд нимгэн хувцаслана.

6.3.Зөгийчний малгай нь нүүр, толгойг зөгийн хатгалт, нарны хурц гэрлээс хамгаалах хар тортой, агаар сайн нэвтрэх даавуун материалаар хийгдсэн байна. Хар бараан өнгийн эсгий малгай эсвэл зөөлөн материалаар хийсэн малгай хэрэглэж болохгүй. Урт үсийг боох, богиносгох ба малгайнаас гадагш гаргаж болохгүй.

6.4.Бээлий нь ихэвчлэн резин, илгэн байх боловч чөлөөтэй хөдөлж болохоор биетэй материалаар хийгдсэн, тохой хүртэл урт хэмжээтэй, ханцуйвчтай, тохойн хэсэгтээ резинэн бэхэлгээтэй байна. Гялгар гадаргуутай урт бээлий, ханцуйвч хэрэглэж болно.

6.5. Гутал нь түрийтэй, түрий хэсэгтээ бариу байвал сайн. Урт түрийтэй усны гутал болон гялгар гутал өмсөж болно. Шагайгаа хамгаалсан зузаан оймс, даавуу, нягт материалаар хийсэн нэмэлт түрий өмсөж болно.

6.6. Эмнэлгийн анхан шатны тусламжийн хайрцгийг биедээ авч явах буюу тээврийн хэрэгсэл хүрэх газарт байршуулна.

6.7 .Ажлын хувцас нь хөлсний үнэргүй, тогтмол угааж цэвэрлэсэн байна.

6.8. Зөгийн үүрэнд ойртохын өмнө хамгаалах хэрэгслийг бүрэн зөв, өмсөнө. Ажлын дараа үүрнээс сайтар холдож, хамгаалах хэрэгслийг тайлна.

6.9. Хамгаалах хэрэгслийг аюултай хүчин зүйл дуусахаас өмнө тайлж болохгүй.

6.10. Ажил олгогч хамгаалах хэрэгсэлгүй ажилтныг зөгийн суурьт нэвтрүүлэхгүй.

6.11. Ажилтан хамгаалах хэрэгслийг үйлдвэрлэлийн бүсээс гаргаж болохгүй ба тусгайлан тоногдсон өлгүүрт хадгална.

Долоо. Зөгийн бүтээгдэхүүн, гэжээл хадгалахад тавигдах шаардлага

7.1. Сархиаг хадгалах байр нь хуурай, агааржуулалт сайтай, хортон шавьж нэвтрэхээргүй байна. Зориулалтын хадгалах байргүй тохиолдолд эрвээхэй, хулгана нэвтрэхээс хамгаалж хаалттай шүүгээ, хайрцагт хийх, битүү төмөр хавтан, эсвэл банзан суурь дээр тавьсан зөгийн үүрний давхарлагаа корпус дотор хийж, төмөр болон шилэн тавцангаар таглаж хадгална.

7.2. Хуучин, хаягдал сархиаг, лав, илүүцийг хайрцагт хадгална. Лавыг аль болох удаахгүйгээр хайлуулж авна.

7.3. Сүүнцэрийг агаар, гэрэл нэвтрэхгүй битүү орчинд +2-4 °C-д богино хугацаанд, 2-6 °C-аас доош хүйтэнд 6 сараас дээш хугацаагаар хөлдөөж хадгална. Хатаасан сүүнцэрийг тасалгааны хэмд 1-2 жил хадгалж болно.

7.4. Жилийг хатуу хавчаараар битүүмжилсэн гялгар уутанд савлан, нарны гэрэл шууд тусахааргүй, хуурай, цэвэр орчинд +25 °C-аас бага дулаанд хадгална.

7.5. Лавыг уут болон хайрцагт савлан, цементэн гөлгөр шалан дээр хуурай, цэвэр орчинд хадгална.

7.6. Сэмжийг 1, 2.5, 5 кг-аар гялгар уутанд хийж, цаасан хайрцагт савлан, элдэв үнэр, мэрэгч амьтан нэвтрэхээргүй сав, хайрцагт хадгална. Тавиур дээрх давхарласан сэмжнүүдийн зузаан 60 см-ээс хэтрэхгүй байна. Сэмжийг хадгалах орчин нь -5 °C-аас +30 °C-ын хооронд байна.

7.7. Балыг модон, металл, шил, керамик, хуванцар, саванд 30 гр-аас 100 кг хүртэлх хэмжээтэйгээр савлан, нарны шууд тусгалаас хамгаалагдсан, ялаа, зөгий, хорхой, шоргоолж нэвтрэхгүй, цэвэр, хуурай орчинд хадгална.

7.8. Өвлийн улиралд балыг -5 °C-аас доош хөлдөөж болохгүй ба агаарын чийгшил 58 %-иас багагүй, 66%-иас ихгүй байна.

7.9. Балыг элдэв хорт бодис, тоос шороо /гурил/, загас, халуун ногоо, цай, кофе мэтийн хурц үнэртэй бүтээгдэхүүнтэй хамт хадгалж болохгүй.

7.10. Цэцгийн тоос, тоосормогийг мэрэгч амьтан нэвтрэх боломжгүй, агааржуулалт сайтай, хуурай газар хадгална. Агуулахын харьцангуй чийгшил 50-60% байх нь сархиагтай тоосормог хөгцрөхгүй, хатахгүй байх нөхцлийг бүрдүүлнэ.

7.11. Тоосормогтой жаазыг зөгийн хамт өвөлжөөнд хадгалж болох ба хөгцрөхөөс хамгаалж нунтаг элсэн чихэр түрхэнэ.

Найм. Ажил, амралтын горим

8.1. Долоо хоногийн ажлын цаг 40 хүртэл байх ба ажлын өдрийн үргэлжлэх хугацаа 8 хүртэл цаг байна.

8.2. Зөгийг оторлуулах зэрэг онцгой ажлын үед ажлын нийт цаг нь долоо хоногийн ажлын цагаас хэтрэхгүй байна. Хөдөлмөрийн дотоод журмаар тогтоосон өдрийн ажлын цагийг ажил олгогчийн санаачилгаар хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажиллуулсан гэж үзнэ. Хамтын болон хөдөлмөрийн гэрээнд тохиролцоогүй нөхцөлд ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно.

8.3. Ажилтны ажлын цагийг эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийн дагуу богиносгоно.

8.4. Ээлжийн хуваарийг ажил олгогч гаргах ба ажилтныг хоёр ээлжинд дараалан ажиллуулахыг хориглоно.

8.5. Орон нутгийн цагаар 22 цагаас 06 цаг хүртэлх хугацааг шөнийн цагт тооцно.

8.6. Ажлын дараалсан хоёр өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цаг ба түүнээс дээш хугацаатай байна. Амралтын өдөр амрах боломжгүй ажилтныг долоо хоногийн өөр дараалсан хоёр өдөр амруулна.

8.7. Амралт, хоолны завсарлагын эхлэх, дуусах цагийг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна. Ажил олгогч үйлдвэрлэлийн онцлогт нийцсэн ахуйн байрыг бий болгох ба завсарлах боломжгүй ажилтныг хооллох боломжоор хангана.

8.8. Ажил олгогч нь ажилтны ээлжийн амралт, түүний хугацаа, нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдрийг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна.

Ес. Ажилтанд тавигдах шаардлага, эрх

9.1. Ажилтан нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эмнэлгийн анхан шатны тусламж, галын аюулгүй ажиллагааны зохих мэдлэг эзэмшсэн, зааварчилга авсан, зөгийн арчилгаа маллагааны технологи, үндсэн дүрэмтэй танилцсан байна.

9.2. Ажилтан нь ажилд шинээр орохдоо эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт заавал, ажиллах явцад эмнэлгийн үзлэгт үе шаттай хамрагдсан, эрүүл мэндийн сөрөг заалтгүй, харшилгүй байна.

9.3. Ажилтан ажил эхлэхийн өмнө хамгаалах хувцсыг бүрэн өмсч, шаардлагатай багаж хэрэгсэл тоног төхөөрөмжөө шалгана. Ажил дууссаны дараа ажлын байрыг цэгцэлж, тоног төхөөрөмж, хэрэгслийг зориулалтын байранд эмх цэгцтэй хураана.

9.4. Ажилтан зөвхөн ажил олгогчийн заавраар ажиллах ба ажил дууссан тухай түүнд мэдэгдэнэ.

9.5. Ажилтан нь хангалтгүй гэрэлтүүлэг, хурц иртэй багаж, агаарын хүчтэй урсгал, агаар дахь хорт бодисын агууламж, мэдрэлийн болон бие махбодийн ачаалал ихсэх зэрэг физик, хими, биологийн болзошгүй хүчин зүйлээс урьдчилан сэргийлнэ.

9.6. Хортой, аюултай нөхцөлд ажил гүйцэтгэх ажилтан нь аюулгүй ажиллагааны асуудлаар мэргэшсэн байна.

9.7. Ажилтан дараахь үүрэгтэй:

9.7.1. хөдөлмөрийн дотоод журам, үйлдвэрлэлийн технологи, хөдөлмөр хамгааллын зааварт заасан аюулгүй байдал, эрүүл ахуйн аргачлалыг мөрдөх;

9.7.2. ажлын байрыг хөдөлмөр хамгааллын шаардлагын дагуу бэлтгэх;

9.7.3. ажлын багаж, хэрэгсэл, бэхэлгээ, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгслийг зориулалт, зааврын дагуу ашиглах;

9.7.4. осол, гэмтэл гарсан тухай бүр ажил олгогчид мэдээлэх;

9.7.5. хувийн ариун цэвэр сахих.

9.8. Ажилтанд дараах зүйлсийг хориглоно:

9.8.1. ажилд ирэх, ажлын байранд архи, согтууруулах ундаа хэрэглэх;

9.8.2. зориулалтын бус газар тамхи татах.

9.8.3. Зөгийн арчилгаа, маллагааны технологи зөрчих

9.9. Ажилтан дараах эрхтэй:

9.9.1. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд ажиллах;

9.9.2. үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамрагдах;

9.9.3. ажлын байрны нөхцөл, эрүүл мэндэд учирч болох эрсдэл, түүнчлэн үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн талаар бодит мэдээлэл авах.

Арав. Ажил олгогчийн эрх, үүрэг

10.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар ажил олгогч дараах үүрэгтэй:

10.1.1. үйлдвэрлэлийн явцад бий болох хими, физик, биологийн хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, ослын үед үйл ажиллагааг яаралтай зогсоож, аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгах;

10.1.2. ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх;

10.1.3. ажлын байрны онцлогт нийцсэн дүрэм, заавар, журам баталж, мөрдүүлэх;

10.1.4. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар шаардлагатай мэдлэгийг эзэмшсэн байх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг олгох сургалт явуулах, ажилтны мэдлэгийг тогтмол шалгах, зааварчилга, сургалтад хамрагдаагүй, зааварчилга аваагүй, шалгалт өгөөгүй ажилтнаар ажил, үүрэг гүйцэтгүүлэхгүй байх;

10.1.5. хэт халуун буюу хүйтэн, салхитай, хур тунадастай зэрэг задгай газар, халаалтгүй байранд ажиллаж байгаа ажилтныг ахуйн байраар хангах;

10.1.6. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий этгээдийг ажлын байранд саадгүй нэвтрүүлэх;

10.1.7. эрх бүхий этгээдийн шаардлага, дүгнэлтийн дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөрчил, дутагдлыг арилгаж, эргэж мэдэгдэх;

10.1.8.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв, төлөвлөгөө, хамтын гэрээнд тусгаж, зориулалтын дагуу зарцуулах;

10.1.9.дүрмийн 1.2.2-т заасан этгээд нь өөрийн ажиллагчдын аюулгүй, эрүүл ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

10.1.10.ажилтныг Эрүүл мэндийн сайдын 2014 оны 340 дүгээр тушаалаар баталсан “Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам”-д заасны дагуу эрүүл мэндийн үзлэгт хамруулах.

10.2. Ажил олгогч дараах эрхтэй:

10.2.1.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах төсөв, зардлыг баталж, хэрэгжүүлэх;

10.2.2.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг зөрчсөн ажилтанд Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай болон холбогдох бусад хууль, байгууллагын дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэх.

Арван нэг. Онцгой анхаарах ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл

11.1.Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/36 тоот тушаалаар баталсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ын 3.1.5 дахь заалтын дагуу 18 насанд хүрээгүй хүнийг зөгийн аж ахуйд ажиллуулахыг хориглоно.

11.2.MNS 4970:2000 стандартын дагуу эмэгтэй ажилтны гараар нэг удаа өргөх, зөөх ачааны дээд хэмжээ 20 кг, нэг дугуйтай түрдэг тэргэнцэрээр 50 кг, хоёр дугуйтай тэргэнцэрээр тэгш газарт 115 кг, тэгш бус газарт 60 кг, 3 ба 4 дугуйтай тэргэнцэрээр 100 кг байна.

11.3.Хөдөлмөрийн нөхцөлийг хөнгөлөхөөр эмнэлгийн дүгнэлт гарсан бол жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй хүний ажлын цагийг хорогдуулах буюу эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлж болно.

11.4.Жирэмсэн эмэгтэй, найм хүртэлх насны хүүхэдтэй эх, 16 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эх, эцгийг өөрөө зөвшөөрөөгүй тохиолдолд шөнийн буюу илүү цагаар ажиллуулахыг хориглоно.

11.5.Зургаан сар хүртэлх насны хүүхэдтэй буюу нэг хүртэлх насны ихэр хүүхэдтэй эхэд хоёр цагийн, зургаан сараас нэг хүртэлх насны, түүнчлэн нэг нас хүрсэн боловч эмнэлгийн дүгнэлтээр зайлшгүй асаргаа шаардагдах хүүхэдтэй эхэд нэг цагийн завсарлага нэмж олгоно. Энэ нь ганц бие эцэгт хамаарна.

11.6.Хөгжлийн бэрхшээлтэй, одой хүний биеийн байдал нь хөдөлмөр эрхлэхэд саад болохооргүй буюу хөдөлмөрийн нөхцөл нь харшлахгүй бол ажиллуулж болох ба ажлын байрны нөхцөл нь тэдний хөдөлмөрлөх чадварт тохирсон байна.

11.7.Тэтгэвэр авагч ахмад настны хүсэлтээр ажлын өдрийн үргэлжлэх хугацааг богиносгох буюу эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлж болно.

11.8.Туршилтаар болон дагалдангаар, цагаар, улирлын чанартай ажлын байранд ажиллаж буй ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл нь байнгын ажлын байранд ажиллаж буй ажилтныхтай адил түвшинд байна.

11.9.Гүйцэтгэж буй ажлын онцлогийг харгалзан ажилтныг үйлдвэрлэлийн нутаг дэвсгэрт түр болон байнга амьдрах, үндсэн байрнаас алслагдмал, удаан хугацаагаар ажиллах ажилтныг ахуйн нөхцөлөөр хангах арга хэмжээ авна.

Арван хоёр. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнийг бүртгэх, шимтгэл, нөхөн олговор

12.1.Энэхүү дүрмийн 1.2-т заасан хөдөлмөр эрхлэгч иргэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод дараах тохиолдолд өртсөний улмаас гэмтсэн, өвчилсөн, эсхүл амь насаа алдсан бол акт тогтооно:

12.1.1.ажлын байрандаа ажил үүргээ гүйцэтгэж байх үед;

12.1.2.ажлын байр, үйлдвэрлэлийн бусад нэгж, хэсэг хооронд байнга явж ажилладаг ажилтан ажлын цагаар бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр буюу явган явж байх үед;

12.1.3.ажилтан ажил эхлэхийн өмнө болон дууссаны дараа ажлын байрандаа амрах, багаж хэрэгслээ эмхэлж цэгцлэх, хувцсаа солих, усанд орох, ажил хүлээлцэх үед;

12.1.4.ажилтан ажилдаа ирэх, буцах зам (ажлын байр болон ажилтай холбоотой сургалтад оролцож байгаа, түр болон байнга оршин суудаг газар, голлон хооллодог, цалингаа авдаг

газрын хооронд)-даа бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр буюу явган явж байх үед;

12.1.5.ажил, үүргээ гүйцэтгэх үед байгаль, цаг уур, гал, усны гэнэтийн аюул, химийн бодисын нөлөөлөл, биологийн гаралтай гоц халдварт өвчин үүсгэгч, хөнөөх хэрэгсэл зэрэг гамшгийн үед.

12.2. Дүрмийн 12.1.4-т заасан ослыг судлан бүртгэхэд нөхцөл байдлын чиглэл, маршрут, цаг хугацаа зэргийг үндэслэнэ.

12.3. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимыг санаатай зөрчсөн болон согтууруулах ундаа мансууруулах бодис хэрэглэсний улмаас осолд өртсөн, гэмт хэрэг үйлдэх үед өөрийн биед гэмтэл учруулсан нь нотлогдсон тохиолдолд актад энэ тухай тусгайлан тэмдэглэнэ.

12.4. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, тайлагнах, мэдээлэх, маргаан шийдвэрлэх асуудлыг Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ээр зохицуулна.

12.5. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн иргэн, ажилтныг өөрийн зардлаар эмнэлэгт хүргэх, шаардлагатай үзлэг шинжилгээний зардлыг хариуцах, осол, хурц хордлогын хор уршгийг арилгах арга хэмжээг 24 цагийн дотор авна. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судалж бүртгэх зардлыг ажил олгогч хариуцна.

12.6. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг нуун дарагдуулахыг хориглох ба ослын тохиолдлыг тухай бүр 12.4-т заасан дүрмийн дагуу судлан бүртгэж, мэдээлэх үүрэгтэй.

12.7. Осолдогч ажил, үүргээ гүйцэтгэж байх үедээ зам тээврийн осолд орсон тохиолдлыг замын цагдаагийн байгууллагын дүгнэлтийн дагуу хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч судалж баталгаажуулна.

12.8. Ажил олгогч нь Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд Засгийн газрын 2008 оны 142 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн ослын даатгалын шимтгэлийн жагсаалт”-д заасан хэмжээ буюу 0.8 %-иар шимтгэл төлнө.

12.9. Ажилтны үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд олгох төлбөр, тусламж үйлчилгээний зардал, тэтгэмж, тэтгэврийг “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-иар зохицуулна.

Арван гурав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт

13.1. Ажил олгогч, ажилтан нь Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/33 тоот тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, шалгалт авах журам”-ын дагуу сургалтад хамрагдаж, мэдлэг, дадлагатай болсон байна.

13.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт нь дараах төрөлтэй байна:

13.2.1. шинээр ажилд орж байгаа иргэний сургалт;

13.2.2. өөр ажлын байранд шилжиж байгаа ажилтны сургалт;

13.2.3. үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтны сургалт.

13.3. Ажил олгогч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад нийт ажилтныг жилд 2-оос доошгүй удаа хамруулж, шалгалт авна.

Арван дөрөв. Хяналт

14.1. Зөгийн аж ахуй нь Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 тоот тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив”-ын дагуу 20-иос дээш ажилтантай бол хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөл байгуулах ба уг хэмжээнд хүрэхгүй тохиолдолд чиг үүргийг мэргэшсэн байгууллага, ажилтнаар гэрээгээр гүйцэтгүүлнэ.

14.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих төрийн захиргааны хяналтыг бүх шатны Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллага, алба, улсын байцаагч, аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан эрх хэмжээний хүрээнд тавина.

14.3. Ажилтны хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах болон төрийн бус байгууллага олон нийтийн хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

14.3.1. үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын талаар үнэн зөв мэдээлэл авах;

14.3.2. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи хууль тогтоомжийн зөрчлийг арилгах шаардлагыг ажил олгогчид тавих;

14.3.3. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар үүссэн маргааныг хэлэлцэх, шийдвэрлэхэд оролцох;

14.3.4. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл хөдөлмөрийн нөхцөлийг дордуулсан, ажилтны эрүүл мэнд, амь насыг хамгаалах үүргээ биелүүлэхгүй байгаа албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх саналаа холбогдох байгууллагад тавих.

14.4. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн бүх хэсэг, ажлын байр бүрт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, нийтлэг шаардлага, стандартын хэрэгжилт, ажлын байран дахь эрсдэлийн үнэлгээний дагуу авагдсан арга хэмжээний биелэлтэд дотоодын хяналт тавина.

14.5. Ажил олгогч нь дотоодын хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авах үүрэгтэй.

14.6. Ажилтан нь аж ахуйн нэгжийн дотоодын хяналтад оролцох эрхтэй.

Арван тав. Санхүүжилт

15.1.3өгийн аж ахуй нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2 дахь заалтын дагуу үйлдвэрлэлийн зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх дараах арга хэмжээнд зарцуулна:

15.1.1. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгаа;

15.1.2. ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамруулах;

15.1.3. ажилтныг сувилах, хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн сэргээх;

15.1.4. ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл;

15.1.5. ажлын байр, үйлдвэрлэлийн орчны аюул, эрсдэлгүй байдлыг хангах;

15.1.6. ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах.

15.1.7. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээ.

15.2. Ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи аливаа арга хэмжээний зардлыг хариуцахгүй.

Арван зургаа. Хариуцлага

16.1. Энэ дүрмийн холбогдох заалтыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж нь Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ТАНИЛЦУУЛГА

Зөгийн аж ахуйд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн төслийн талаар

Монгол Улсад зөгийн аж ахуйн хөгжил нь 1958 оноос эхлэлтэй бөгөөд экологид ээлтэй, органик ХАА салбарын нэг бүрэлдэхүүн хэсэг болгон хөгжүүлж, өнөөдрийн байдлаар 900 өрх, аж ахуйн нэгж 12.3 мянган бүл зөгийг өсгөн үржүүлж байна.

Засгийн газрын 2018 оны 400 дугаар тогтоолоор батлагдсан “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрт зөгийн аж ахуй эрхлэгчдийг бүсчлэл, хамтын ажиллагаагаар кластерын зохион байгуулалтад оруулж, үйлдвэрлэлийн технологи, зөгийчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулан, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, зах зээлд бэлтгэн нийлүүлэх зөгийн бал, бусад дагалдах бүтээгдэхүүний хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлж, 2023 онд импортын зөгийн балыг 70 хүртэл хувиар бууруулж, экспортыг 10 хувиар нэмэгдүүлэх зорилт, үйл ажиллагааг тусгасан.

Зөгийн аж ахуйн үйлдвэрлэл нь байгаль, цаг агаарын хүчин зүйлээс хамааралтай тул ажиллагчид нь хэт халуунд удаан хугацаагаар гадаа ажиллах, зөгийн отрыг дагаж / 5-6 сар / орон гэрээс алслагдмал зайнд амьдрах нөхцөл /амьдрах болон ахуйн байргүй байх/ хүнд, зохисгүй хооллолт, ажлын онцлогоос /байнга бөхийж ажиллах, хүнд зүйл өргөх/ шалтгаалан булчин, ясны өвчлөл, артрит, остеоартрит, нуруу, дискний суулт, эргэлтийн системийн өөрчлөлт, венийн судасны өргөсөлт, зөгийн хорноос үүдэлтэй аллерги, шавьж, амьтанд хатгуулж хордон түр болон удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдах, араатан амьтдын аюул зэрэг асуудлуудтай тулгардаг.

НҮБ-ын ХХААБ-ын судалгаагаар ХАА-н салбарт 100 ажиллагсад тутамд 6,8 осол гэмтэл бүртгэгдэж байдгийн тодорхой хувь нь зөгийн аж ахуйд ногдож байна.

Манай улсад зөгийн үйлдвэрлэл, үржил, үүлдэрлэг байдал, бүтээгдэхүүний үр ашгийн талаар олон судалгаа, шинжилгээний ажил хийгдсэн боловч зөгийчдийн хөдөлмөрийн нөхцөл, эрүүл мэнд, аюулгүй байдлыг нарийвчлан судлаагүй, энэ чиглэлээр эрх зүйн ямар нэг зохицуулалтгүй байна.

Тус яам 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө зөгийн аж ахуйд ажиллагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл байдлыг судлан, сайжруулах чиглэлээр холбогдох эрх зүйн баримт бичгийг боловсруулж, мөрдүүлэхээр тусгасны дагуу “Зөгийн аж ахуйд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийн төслийг боловсруулаад байна.

Дүрмийн төслийг боловсруулахдаа олон улсын болон үндэсний хэмжээнд мөрдөж байгаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хөдөө аж ахуй, зөгийн аж ахуйн үйлдвэрлэлтэй холбоотой олон улсын гэрээ, Конвенци – 2, УИХ, Засгийн газраас баталсан бодлого, хөтөлбөр – 7, Монгол Улсын хууль – 7, Засгийн газар болон эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам – 8, холбогдох бусад эрх зүйн акт – 2, Монгол Улсын Үндэсний стандарт – 3, Мэргэжлийн хяналтын газраас баталсан хяналтын шалгах хуудас – 2 зэрэг баримт бичгүүдийг судалсны дотор олон улсын гэрээ, Конвенцийн 24 бүлэг, 29 зүйл, Монгол Улсын 7 хуулийн 47 бүлэг, 340 зүйл, 803 заалт, УИХ, Засгийн газраас баталсан 3 бодлого, үндэсний 4 хөтөлбөрийн 51 бүлэг асуудлыг илүү нарийвчлан судалсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар онцлох зарим салбар, аж ахуйн нэгжийн дүрэм, журам, үндэсний стандартуудыг мөн судалсан.

Дүрмийн практик хэрэгцээг тодорхойлохдоо Төв Европын улс орнууд, Турк, ОХУ, Башкир, Аргентины жишээн дээр зөгийчдөд нийтлэг тохиолддог аюул, осол, гэмтлийн нөхцөл байдал, НҮБ, АНУ, Австрали улсуудын гарын авлага, үндэсний эрдэмтдийн 10 гаруй судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг судалсан болно.

Эрх зүйн дүн шинжилгээ, практик хэрэгцээг үндэслэн дүрмийн төслийг дараах бүтэцтэйгээр боловсруулав. Үүнд:

1. Нийтлэг үндэслэл
2. Нэр томьёо
3. Үйлдвэрлэлийн явц дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага
4. Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага
5. Галын аюулгүй байдалд тавигдах шаардлага
6. Ажилтны хамгаалах хэрэгсэлд тавигдах шаардлага
7. Зөгийн бүтээгдэхүүн, тэжээл хадгалахад тавигдах шаардлага
8. Ажил, амралтын горим
9. Ажилтанд тавигдах шаардлага, эрх
10. Ажил олгогчийн эрх, үүрэг

11. Онцгой анхаарах ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл
12. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнийг бүртгэх, шимтгэл, нөхөн олговор
13. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт
14. Хяналт
15. Санхүүжилт
16. Хариуцлага

Төсөлд дүрмийн зорилго, зарчмыг Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Органик хүнсний тухай хуулиуд, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тавдахь хөтөлбөр”-т хүний хөдөлмөрлөх үндсэн эрхийг хангах, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих үндсэн зорилготой нийцүүлэн тодорхойлов.

Төсөлд дүрмийн үйлчлэх хүрээг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан хүрээгээр авч үзсэн ба өөрөөр хэлбэл, /Хөдөлмөрийн тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан ажил олгогч, ажилтан; хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, иргэд хоорондын гэрээгээр ажиллагчид, хоршоо, нөхөрлөлийн гишүүд/-ийг хамруулахаар төсөлд тусгасан.

Төсөлд дүрмийн агуулгыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн бүтэц, агуулгыг үндэслэн, 16 бүлэгтэйгээр боловсруулсан.

Төсөлд Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ОУХБ-ын 184 дүгээр Конвенци, Хөдөлмөрийн тухай хуулиар тодорхойлсон онцгой бүлэг болох насанд хүрээгүй хүн, эмэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настай ажилтан, хөхүүл, жирэмсэн эмэгтэйчүүд, туршилтын болон дагалдан, улирлын чанартай ажиллагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг тусгайлан авч үзсэн.

Төсөлд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тохиолдлыг судлан бүртгэх, бүртгэгдсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хуульд заасны дагуу Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санд ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээ, уг сангаас ажилтанд олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээний зардлыг хэрхэн олгох асуудлыг тусгасан.

Дүрмийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 22.1.2, 22.1.3 дахь заалтыг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар боловсруулсан болно.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ